



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/264

Хэрлэн сум

7 суманд дэмжлэг үзүүлж
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 8 дугаар хуралдааны “Аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Иргэдийн оролцоот-Хэтийн Хэнтий арга хэмжээний хүрээнд 2022 оны төлөвлөгөөний дагуу төсөл хэрэгжүүлж буй 7 сумын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж 21,000,000 (хорин нэгэн сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Дэмжлэг үзүүлэх сумдын нэрс, мөнгөн дүнг хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд зарцуулах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн “Иргэдийн оролцоот хэтийн Хэнтий” арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа), гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны
... дугаар сарын ... өдрийн
... дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Сумын нэр	Мөнгөн дүн
1	Батноров	3,000,000
2	Батширээт	3,000,000
3	Бор-Өндөр	3,000,000
4	Галшар	3,000,000
5	Дадал	3,000,000
6	Мөрөн	3,000,000
7	Цэнхэрмандал	3,000,000
Нийт		21,000,000